

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО ТАЙЛАН

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тухай хууль батлагдсанаар үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу урьдчилсан байдлаар тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Уг аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр хувь хүн, хуулийн этгээдэд бус төрийн байгууллагад тодорхой зардал үүсэхээр тусгасан байна.

ИРГЭНИЙ ҮҮСЭХ ЗАРДАЛ

Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Иргэн төрийн үйлчилгээ авахад төлбөр, хураамж гарахгүй.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДАЛ

Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй. Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны хувьд нэмэлт орон тоо, шинэ ажлын байр шаардахгүй тул нэмэлт зардал гарахгүй.

УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт санхүүгийн нөлөөлөлийг тооцоходоо дараах зарчмыг баримталсан болно.

- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах

Хууль тогтоомжийн зохицуулалт

Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээ” гэсэн төрөлтэй байхаар зохицуулсан байдаг бөгөөд салбарын хэмжээнд батлагдсан төсвийн хүрээнд зардлын хязгаарт багтаан нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг зохион байгуулж ирсэн.

УИХ-аас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хийх хууль эрх зүйн орчныг бий болгож Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн тогтолцоогоор дамжсан шинэчлэлийг хэрэгжүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.3

болон 24.6.4-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлэх зохицуулалт хэвээр байна.

Энэхүү хуулийн төслийн 5 дугаар зүйлд заасан нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний төрлийг тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т "Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусlamж, үйлчилгээний орлого, хандив тусlamжийг зарцуулах журмыг эрүүл мэнд, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж тусгаж зохицуулсан бөгөөд одоо байгаа нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний өртөг, зардлыг тооцож салбарын санхүүжилтийн шинэчлэлтэй уялдуулж, үр дүнг тооцох боломжтой болгохоор журамлана. Суурь судалгааны ажил хийгдэж байна.

Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төсөлд тусгагдсан нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд тогтолцоо, бүтэц, төсвийн шууд захирагчийг шинээр зохион байгуулах шаардлагагүй. Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагууд нь Эрүүл мэндийн мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөл юм.

Хуулийн төслийн 7.1.2-т заасан "аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв" гэдэг байгууллагын хувьд одоогийн байгаа эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, нэгтгэх замаар тусlamж, үйлчилгээгээр нь төрөлжүүлж, өөрчлөх бодлогыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний төрлийн зардлын тооцоололыг хийхэд дараах байдалтай байна.

| Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний төрөл | Чиг үүргийн зохицуулалт | Санхүүжилтийн зохицуулалт |
|--|---|---|
| 5.3.1.тандалт, судалгаа; | Халдварт болон халдварт бус өвчиний тандалт, судалгааны чиг үүргийг үндэсний хэмжээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Зооноз өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвүүд, аймаг, нийслэлийн түвшинд Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төв зэрэг байгууллагууд гүйцэтгэж байна. | 1. Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл, согог судлалын үндэсний төвүүд нь эдгээр үйл ажиллагааг эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлсэн орлогоороо дотооддоо зохицуулан ажиллаж байгаа хэдий ч төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үр дүн багатай, мөн тусlamж үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг зардал хуваалцах зарчмаар үзүүлж байгаа сул талтай байна. Цаашид эдгээр байгууллагуудын үндэсний хэмжээнд тандалт, судалгаа явуулах үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай байна. |
| 5.3.2.эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох; | Эрүүл мэндийн дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг үндэсний хэмжээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Зооноз өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн түвшинд Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төвүүд харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж байна. | 1. Эдгээр байгууллагын ургал үйл ажиллагааны зардлыг 100% улсын төсвөөс санхүүжүүлж байна. Цаашид Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний багц, жишиг үнийг тогтоож, журамаар зохицуулна. 2. Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан "Бүх шатны Засаг даргын бүрэн эрх"-ийн хүрээнд иргэдийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгоход нэмэлт санхүүжилтийн дэмжлэгийг үзүүлж хамтран ажиллаж байна. |

| | | |
|--|--|---|
| 5.3.3.урьдчилан сэргийлэх, үнэлэх, хянах; | <p>Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах чиг үүргийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар үндэсний хэмжээнд зохион байгуулж байна.</p> <p>Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд ХӨСҮТ хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> | <p>1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтооолоор батлагдсан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Цаашид холбогдох журамд өөрчлелт оруулах, хөдөлмөрлөх насны эдийн засгийн идэвхитэй хүн амын хамралтын хувийг нэмэгдүүлэх тарифын хөшүүргийг хийхтэй холбоотой зардал нэмэгдэж байна. Нэмэлтээр 40 тэрбум төгрөг./</p> <p>2. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд улсын төсвөөс 22,5 тэрбум төгрөгийн санхүүжүүлж байна.</p> |
| 5.3.4.нийгмийн эрүүл мэндийн бодлого, удирдлага; | Үндэсний түвшинд ЭМЯ, НЭМҮТ, аймаг, дүүргийн түвшинд эрүүл мэндийн газрууд гүйцэтгэж байна. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн дэмжих сангаас төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр жилд 2,3 тэрбум төгрөг зарцуулж байна. Цаашид эрүүл мэндийн дэмжих санд санхүүжилтийн эх үүсвэрэйг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж (11.7 тэрбум төгрөг) Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд чиглэсэн арга хэмжээг санхүүжүүлэх хэрэгцээ байна. |
| 5.3.5.олон нийтийн түншлэл, хамтын ажиллагаа. | <p>1. Олон нийтийн түншлэл, хамтын ажиллагааны хувьд Засгийн газар хоорондын амлалтын дагуу Глобаль сантай тогтвортой хамтын ажиллагаатай ажиллаж байна. 2024-2026 онд хамтран ажиллах амлалтыг байгуулсан.</p> <p>2. Мөн ДЭМБ, НҮБ-Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагатай түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүргийг тасралтгүй гүйцэтгэж байна.</p> | Глобаль сан, ДЭМБ, НҮБ, бусад байгууллагаас нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд жил бүр 18-20 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бүрдүүлж ажиллаж байна. Цаашид олон улсын байгууллагын санхүүжилтийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэж буй нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний санхүүжилтийг улсын төсвийн эх үүсвэрээр нэмэгдүүлэх шаардлагатай байна. |

Зардлыг нэгтгэн тооцох

- Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл болсон халдварт өвчиний тандалт, судалгааны чиг үүргийг хариуцаж буй Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт сэргийлэлтийн нэгжийн үйл ажиллагааны зардлын тооцоололыг гаргахад нийт 32,7 тэрбум төгрөг шаардлагатай байна.

/ сая.төгрөгөөр/

| № | Үйл ажиллагааны чиглэл | Нийт шаардлагатай төсөв | Үүнээс | |
|---|---|-------------------------|------------------------|-------------|
| | | | Олон улсын байгууллага | Эх үүсвэрэй |
| 1 | ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба | 3,276.8 | 2,434.4 | 842.4 |
| 2 | Сурьеэгийн тандалт судалгааны алба | 11,268.8 | 6,826.8 | 4,442.0 |
| 3 | Талбарын тархвар судлалын алба | 1,173.2 | 906.7 | 266.5 |
| 4 | Дархлаажуулалтын алба | 3,856.2 | 3,186.6 | 669.6 |
| 5 | Халдварт өвчиний тандалт, судалгааны алба | 7,105.0 | 6,469.8 | 635.2 |
| 6 | Нэгдсэн лабораторийн алба | 6,045.4 | 531.2 | 5,514.2 |
| 7 | Нийт санхүүжилт | 32,725.4 | 20,355.5 | 12,369.9 |

2. МУ-ЫН ЗГ-ЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБЕРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТӨСВИЙН ТООЦООЛОЛЫГ ГАРГАХАД 126,1 ТЭРБУМ ТӨГРӨГ ШААРДЛАГАТАЙ ТООЦООЛОЛ ГАРСАН БАЙНА.

/ сая.төгрөгөөр/

| № | Үйл ажиллагааны нэр | Эрүүл мэндийн сайдын тушаал, заавар | Хэрэгжих хугацаа | Нийт төсөв | Санхүүжилтийн эх үүсвэр | |
|----------|--|--|------------------|------------|-------------------------|--------------------|
| | | | | | Улсын төсөв | Бусад эх үүсвэрээр |
| 1. | "Эрүүл идэвхитэй амьдрал" арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2021.12.13-ны өдрийн A/780 дугаар тушаал | 2021-2024 | 1,500.0 | 500.0 | 1,000.0 |
| 2. | "Эх, хүүхэд нөхөн үргижүйн эрүүл мэнд" арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2021.12.09-ний өдрийн A/760 дугаар тушаал | 2021-2024 | 11,700.0 | 10,500.0 | 1,200.0 |
| 3. | "Хавдрын эсрэг" арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2021.06.10-ны өдрийн A/360 дугаар тушаал | 2021-2024 | 13,400.0 | 9,500.0 | 3,900.0 |
| 4. | "Харшлаас сэргийлэх" арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2021.12.31-ний өдрийн A/816 дугаар тушаал | 2021-2024 | 600.0 | 600.0 | - |
| 5. | "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2021.09.09-ний өдрийн A/559 дүгээр тушаал | 2021-2024 | 1,500.0 | 1,050.0 | 450.0 |
| 6. | Халдварт ёвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2022.10.31-ний өдрийн A/528 дугаар тушаал | 2022-2025 | 48,933.2 | 15,128.1 | 33,805.1 |
| 7. | Орчны эрүүл мэнд хөтөлбөр, арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2021.05.31-ний өдрийн A/349 дугаар тушаал | 2021-2024 | 500.0 | 500.0 | - |
| 8. | "Элэг бүтэн Монгол" арга хэмжээ | Эрүүл мэндийн сайдын 2022.12.05-ний өдрийн A/577 дугаар тушаал | 2022-2025 | 48,037.4 | 650.0 | 47,387.4 |
| Нийт дүн | | | | 126,170.6 | 38,428.1 | 87,742.5 |

Хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт шаардлагатай зардал = 50,7 тэрбум төгрөг

Нэмэлт орлогын эх үүсвэрийг тооцоолоход:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь хандив, тусlamж, эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөс бүрдэнэ гэж заасан байдаг. Мөн тус хуулийн 19.3 дахь хэсэгт Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгагдсан байдаг.

Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор Эрүүл мэндийг дэмжих санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайдад, Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайдад тус тус даалгасан. Үүний дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд жилд дунджаар 3 орчим тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад баталж өгдөг.

Архи, согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өргтийн албан татварын орлогоос Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан хувиар тооцож үзэхэд 2023 онд 15 тэрбум төгрөгийг эрүүл мэндийг дэмжих санд гүйцэтгэлээр хуваарилан олгох боломжтой байгаа хэдий ч 2.7 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилсан байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих санд татан төвлөрүүлэх орлогыг бүрэн татан төвлөрүүлж, Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад хуваарилж олговол өмнө нь дэмжих сангийн санхүүжилтээр хийгдэж байсан арга хэмжээнүүдээс гадна шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөгөө (“Элэг бүтэн Монгол”, “Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” г.м.)-г хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх эх үүсвэрийн нэг хэлбэр болох Эрүүл мэндийн дэмжих сангийн төсвийн тооцоололыг гаргаж тооцоолол хийсэн.

сая. төг

| № | Татварын төрөл | 2022 | 2023 |
|---|---|------------------|------------------|
| 1 | Архи, согтууруулах ундааны онцгой албан татварын орлого | 280,200.0 | 378,000.0 |
| 2 | Тамхины онцгой албан татварын орлого | 192,000.0 | 198,000.0 |
| 3 | Эмийн импортын гаалийн болон НӨАТ-ын орлого | 353,466.7 | 363,755.6 |
| | Дүн (архи, тамхи, эм) | 825,666.7 | 939,755.6 |

Үүнээс дэмжих санд төвлөрүүлэх санхүүжилт

| № | Татварын төрөл | 2022 | 2023 |
|---|---|-----------------|-----------------|
| 1 | Архи, согтууруулах ундааны онцгой албан татварын орлого | 2,802.0 | 3,780.0 |
| 2 | Тамхины онцгой албан татварын орлого | 3,840.0 | 3,960.0 |
| 3 | Эмийн импортын гаалийн болон НӨАТ-ын орлого | 7,069.3 | 7,275.1 |
| | Дүн (архи, тамхи, эм) | 13,711.3 | 15,015.1 |

Эрүүл мэндийн дэмжих сангийн зарцуулалт:

| № | Үйл ажиллагаа | 2020 он | | 2021 он | | 2022 он | |
|---|---|-------------|---------------|-------------|---------------|-------------|---------------|
| | | Төслийн тоо | Санхүүжилт | Төслийн тоо | Санхүүжилт | Төслийн тоо | Санхүүжилт |
| 1 | Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх | 23 | 382,239,340 | 34 | 1,091,517,100 | 32 | 1,388,293,372 |
| 2 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 7 | 172,656,660 | 16 | 398,542,700 | 2 | 67,825,000 |
| 3 | Орчны эрүүл мэндийг хамгаалах | 21 | 1,665,014,000 | 1 | 20,721,750 | 3 | 83,578,000 |
| 4 | Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бурдуулэх | 5 | 152,232,400 | 10 | 298,969,000 | 15 | 545,725,090 |

| | | | | | | | |
|-----------------|---|-----------|----------------------|-----------|----------------------|-----------|----------------------|
| 5 | Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууроолах бодисын хорт нөлөөлөөс сэргийлэх | 5 | 91,774,600 | 15 | 455,239,650 | 9 | 273,147,810 |
| 6 | Эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах | 2 | 46,782,850 | 4 | 64,518,000 | 4 | 98,485,000 |
| 7 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, ЭМБ-ын ил тод байдал, хариуцлагыг дээшилүүлэх | 3 | 78,190,000 | 7 | 176,730,000 | 8 | 377,586,525 |
| Нийт дүн | | 66 | 2,588,889,850 | 87 | 2,506,238,200 | 73 | 2,834,640,797 |

Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хууль хэрэгжсэнээр урт хугацаанд эрүүл мэндийн салбарын зардал буурах, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, нийтийн эрүүл мэнд сайжрах боломжтой.

-----оОо-----